

## **СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ ҮЙЛДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН НЭРИЙН ЖАГСААЛТТАЙ ТАНИЛЦАХ, АШИГЛАХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.16, 20.21 дэх хэсэгт заасан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглахад энэ журмыг баримтална.

1.2.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглахад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийг баримтална.

1.3.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагааг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сонгуулийн ерөнхий хороо, Тагнуулын байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, байгууллагын нууц хариуцсан ажилтан хяналт тавина.

### **Хоёр.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл**

#### **ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах**

2.1.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай дараах эрх бүхий этгээд /цаашид “**төлөөлөл**”гэх/ танилцах хүсэлт гаргана.

2.1.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт заасан Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлж, батламж авсан эрх бүхий этгээд;

2.1.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.8 дахь заалтад заасан бие даан нэр дэвшигчийн төлөөлөхөөр Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн эрх бүхий этгээд;

2.1.3.Сонгуулийн ерөнхий хороонд холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгүүлсэн, төрийн бус байгууллагын төлөөлөл.

### **Гурав.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл**

#### **ажиллагаатай танилцах**

3.1.Энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан эрх бүхий этгээдийн төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалттай танилцахдаа жижүүр, санал авах байрны хамгаалалтад ажиллаж байгаа цагдаагийн албан хаагчид биеийн байцаалтыг шалгуулж нэвтрэх бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл заалтын мөрдлөг болгож, хувь хүний нууцыг хамгаалах, нууц задруулахгүй байх баталгаа гаргана.

3.2.Эрх бүхий этгээд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно.

3.2.1.Үйл ажиллагааны явцад дуу дүрсний бичлэг хийх зориулалт бүхий тоног, төхөөрөмж оруулах

3.2.2.Зураг авах, шууд дамжуулах зэргээр бусдын мэдээллийг тараах;

3.2.3.Тухайн байгууллагын үйл ажиллагааг үл хүндэтгэн, зохион байгуулж байгаа арга хэмжээнд хүндрэл саад учруулах;

3.2.4.Бусдын мэдээллийг хуульд зааснаас бусад хэлбэрээр авахыг шаардах;

3.2.5.Үйл ажиллагаанд хувийн байдлаар хандаж, олж авсан мэдээллийг хуульд зааснаас бусад зорилгоор ашиглах;

3.2.6.Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх;

3.2.7.Хутга мэс,тэсэрч дэлбэрэх болон химийн шатамхай бодис оруулах, нэвтрүүлэх;

### **Дөрөв.Сонгогчдын нэрийн жагсаалтыг ашиглах**

4.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэгт заасны дагуу ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтээр сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд заасан хугацаанд, Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан “Маягт-20”-ын дагуу тэмдэглэл үйлдэж олгоно.

4.2.Сонгогчдын нэрийн жагсаалтыг авах эрх бүхий этгээд бусдын нууцыг задруулахгүй байх баталгааг гаргаж, албажуулсан байна.

4.3.Сонгогчдын нэрийн жагсаалтыг авах эрх бүхий этгээд дараах үүргийг хүлээнэ:

4.3.1.Сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэж, олшруулах, цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах зэргээр тараахыг хориглох бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, нууцыг задруулахгүй байх;

4.3.2.Хуульд заагаагүй иргэн, эрх бүхий этгээд олж авах нөхцөл боломжийг бүрдүүлж, бусдад давуу байдал бий болгох, сонгогчдын нэрийн жагсаалтыг зарж наймаалцах, үрэгдүүлэхгүй байх;

4.3.3.Эрх бүхий этгээд нэрийн жагсаалтыг хэрхэн ашигласан тухай мэдээллийг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сонгуулийн ерөнхий хороо, Тагнуулын байгууллагад эргэж мэдэгдэх;

4.3.4.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хуульд заасны дагуу олгосон сонгогчдын нэрийн жагсаалтыг авсан эрх бүхий этгээд уг нэрийн жагсаалтыг сонгуулийн санал хураалт явагдаж дууссаны дараа ажлын 3 хоногийн дотор буцаан хүргүүлэх.

## Тав. Хариуцлага

5.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---